

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-3047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Д.НАРАНБААТАР ТАНАА

᠒᠐2᠖-᠐3-᠒3 № ᠒᠗-᠒᠐26/᠐᠐1/НА-СНА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 7 дугаар зүйлийн 7.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14.4, 14.4.3, 20.2, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1, 15.1.8, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, ЗДТГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-

4326050351

ний өдрийн тушаалтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 89,012.3 мянган төгрөгөөр тасалсан,
- ЗДТГ нь 8,269.9 мянган төгрөгийг зориулалт бусаар буюу зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Санхүүгийн тайланд ТТЗ-ийн 2,377.0 мянган төгрөг, ЗДТГ-ын 989.7 мянган төгрөг нийт 3,366.7 мянган төгрөгийн 5-аас дээш жилийн насжилттай авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулаагүй,
- Сумын ИТХ нь төлөөлөгчдийг чадавхжуулах төсвөөс 2,200.0 мянган төгрөгийг спортын тэмцээн, уралдааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан,
- Өмнөх санхүүгийн тайланд тусгагдаагүй нийт 2,005.2 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан,
- Сумын ИТХ, ЗДТГ нь албан тушаалыг хавсран болон түр орлон гүйцэтгүүлэхдээ цалинг зөрүүтэй тооцоноос шалтгаалан 1,482.1 мянган төгрөгийг илүү тооцож олгосон,
- Сумын ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн 330.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орхонтуул сумын ИТХ-ын "2025 оны тодотгосон төсөв батлах тухай" 39 дүгээр тогтоолоор тайлант онд 1,132,924.8 мянган төгрөгийн татварын орлого, 25,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, зэрэг нийт 1,157,924.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,068,912.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 7.7 хувиар тасалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 14-ийг нь бүрэн хэрэгжүүлсэн бол цахим тендерт санал ирүүлээгүй, хугацаа оройтож гэрээ байгуулсан, малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө тасарсан зэргээс шалтгаалж 3 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 6 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Орхонтуул сумын Засаг дарга нь тайлант онд 3 зорилт, 129 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.4 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,241,788.39	9,022,586.81
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	2,002,990.96	2,514,743.63
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	157,849.53	112,095.19
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	80,947.9	6,395,747.98
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,622,010.26	4,204,253.52
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	9,622,010.26	4,204,253.52
7	Биет хөрөнгө		9,121,152.66	3,703,545.92
8	Биет бус хөрөнгө	13	500,857.6	500,707.6
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		11,863,798.65	13,226,840.32
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР		28,716.65	45,920.92
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		28,716.65	45,920.92
12	Өглөг		28,716.65	45,920.92
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,835,082	13,180,919.41
14	Засгийн газрын хувь оролцоо		11,835,082	13,180,919.41
15	Засгийн газрын оруулсан капитал		520,089.05	520,089.05
16	Хуримтлагдсан үр дүн		10,712,815.62	12,058,653.03
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		602,177.33	602,177.33
18	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		11,863,798.65	13,226,840.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		4,979,377.37	11,046,196.1
2	ТАТВАРЫН ОРЛОГО		869,572.84	1,029,767.02
3	Орлогын албан татвар		559,179.27	569,407.94
4	Хувь хүний орлогын албан татвар		609,665.66	617,874.99
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(50,486.39)	(48,467.05)
6	Хөрөнгийн албан татвар		222,869.87	336,828.86
7	Бусад татвар, төлбөр, хураамж		87,523.69	123,530.22
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	915,246.22	10,016,429.08
9	Тусламжийн орлого		0.00	1,590,458.35
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,194,558.31	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,536,936.46	2,384,454.04
12	УРСГАЛ ЗАРДАЛ		2,536,936.46	2,384,454.04
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,508,824.01	2,358,184.64
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,001,538.33	1,058,096.42
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		124,272.22	127,755.17
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		590,864.87	586,391.82
17	Хангамж, бараа материалын зардал		54,412.23	46,548.74
18	Нормативт зардал		859.00	350.00
19	Эд хогшил, урсгал засварын зардал		23,110.15	19,648.20
20	Томилолт, зочны зардал		8,907.20	7,391.30

21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		32,652.50	42,714.24
22	Бараа үйлчилгээний бусад зардал		672,207.53	469,288.75
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		28,112.45	26,269.4
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,442,440.9	8,661,742.06
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		614,367.82	7,315,904.66
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(614,367.82)	(7,315,904.66)
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		1,828,073.08	1,345,837.40

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,549.05	611,344.00	8,875,575.87	9,949,468.92
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,166.67	9,166.67
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,549.05	611,344.00	8,884,742.54	9,958,635.59
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(9,166.67)	-	(9,166.67)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	57,540.00	-	-	57,540.00
6	Тайлант үеийн үр дүн	-	-	1,828,073.08	1,828,073.08
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,089.05	602,177.33	10,712,815.62	11,835,082.00
8	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	520,089.05	602,177.33	10,712,815.62	11,835,082.00
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,089.05	602,177.33	10,712,815.62	11,835,082.00
10	Тайлант үеийн үр дүн	-	-	1,345,837.40	1,345,837.40
11	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	520,089.05	602,177.33	12,058,653.03	13,180,919.41

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,208,443.00	3,626,830.59
2	ТАТВАРЫН ОРЛОГО	869,572.84	1,029,767.02
3	Орлогын албан татвар	559,179.27	569,407.94

4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(50,486.39)	(48,467.05)
5	Хөрөнгийн албан татвар	222,869.87	336,828.86
6	Бусад татвар, төлбөр, хураамж	87,523.69	123,530.22
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,483.97	6,481.01
8	Газрын төлбөр	52,368.72	100,300.67
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	26,671.00	16,748.55
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	144,311.85	2,597,063.56
11	Нийтлэг татварын бус орлого	144,311.85	110,805.21
12	Тусламжийн орлого	0.00	1,590,458.35
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	895,800.00
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,194,558.31	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,996,842.70	2,017,716.05
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,996,842.70	2,017,716.05
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,968,730.25	1,991,746.65
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,001,402.76	1,058,296.64
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,407.79	128,008.94
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	594,603.07	579,886.82
21	Хангамж, бараа материалын зардал	54,412.23	48,904.10
22	Нормативт зардал	1,060.60	350.00
23	Эд хогшил, урсгал засварын зардал	27,092.61	18,946.50
24	Томиллолт, зочны зардал	8,907.20	7,391.30
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,117.00	41,406.48
26	Бараа үйлчилгээний бусад зардал	125,727.00	108,555.87
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,112.45	25,969.40
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,211,600.3	1,609,114.54
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,086,484.21	1,097,361.86
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,086,484.21	1,097,361.86
31	Дотоод эх үүсвэрээр	1,086,484.21	1,097,361.86
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,086,484.21)	(1,097,361.86)
33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,125,116.09	511,752.68
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	877,874.87	2,002,990.96
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,002,990.96	2,514,743.63

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,887,336.9	3,091,569.1	1,795,767.8	63.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,591,830.8	2,022,475.2	569,355.6	78.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,533,546.5	1,996,505.8	537,040.7	78.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,303,120.5	1,057,537.1	245,583.4	81.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,384.4	127,927.5	47,456.9	72.9

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	659,832.3	579,886.6	79,945.7	87.8
2104	Хангамж, бараа материалын зардал	57,082.0	44,264.2	12,817.8	77.5
2105	Норматив зардал	710.3	350.0	360.3	49.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,059.4	42,214.4	20,845.0	66.9
2107	Томилолт, зочны зардал	14,075.6	7,391.3	9,684.3	52.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хуоаамж	59,734.9	41,406.5	18,328.4	69.3
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	142,262.8	95,528.2	46,734.6	67.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,284.3	25,969.4	32,314.9	44.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,284.3	25,969.4	32,314.9	44.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,202,526.5	1,069,093.9	1,133,432.6	48.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	92,979.6		92,979.6	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,904,062.4	3,427,227.2	476,835.2	87.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,853,562.4	3,380,642.5	472,919.9	87.7
320001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,855,250.9	2,484,842.5	370,408.4	87.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	998,311.5	895,800.0	102,511.5	89.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,500.0	46,584.7	3,915.3	92.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,500.0	46,584.7	3,915.3	92.2
610001	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	33	2	94.2
620001	Удирдах ажилтан	6	6	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21	19	2	90.5
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0
620004	Гэрээт ажилтан	6	6	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,132,252.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,132,252.50
122	Тусламжийн орлого	10,132,252.50
1221	Хандив тусламж /дотоод/	10,132,252.50
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,132,252.50
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,313,586.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,348,666.50
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,470,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,008,619.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,008,619.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,008,619.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	759,582.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,470.95
2104	Хангамж, бараа материалын зардал	4,639,878.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,527,688.00

4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	123,633.10
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(123,633.10)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(123,633.10)

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхонтуул сумын ТТЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын ТТЗ нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/200 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,536,936.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 25,369.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд тус төвлөрүүлэн захирагч нь харьяа байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар тайлант оны эцэст батлагдсан төсвийг 36 хувиар хэмнэсэн байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 293,040.3 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 79,945.5 мянган төгрөгөөр,

- Хангамж, бараа материалын зардлыг 12,817.8 мянган төгрөгөөр, Эд хогшил, урсгал засварын зардлыг 20,845.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 46,734.6 мянган төгрөгөөр,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй зэрэг төсвийн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 35 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад Орхонтуул сумын ИТХ нь спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахад нийт 2,200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсөв төвлөрүүлэн захирагч	157	137	20	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	171	161	10	-
3	Засаг даргын Тамгын газар	171	159	12	-
4	Рашаант тосгоны Захирагчийн алба	171	154	17	-
	Нийт дүн	670	611	59	-

Тус сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын дүнгээр нийт мэдээлбэл зохих 670 мэдээллээс 611 мэдээллийг хугацаанд нь, 59 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд ЗДТГ, ИТХ нь шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөн боловч биелүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 433 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 төлбөрийн акт, 7 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн бол 1 зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,253.7	3	1,253.7	100
Албан шаардлага	8	270,079.7	7	269,809.7	99.9
Зөвлөмж	4	88,000.0	4	88,000.0	100
Нийт дүн	15	359,333.4	14	359,063.4	99.9

Өмнөх санхүүгийн тайланд өр төлбөр тусгалгүйгээр тайлант жилд шууд зардлаар тайлагнасан зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам” -ын 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд **Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “... хүчин төгөлдөр болсон **албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ... аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно**” гэсэн заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үйл ажиллагаанд зарцуулсан 28,000.0 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд үнэ төлбөргүй шилжүүлсэн зардлаар тайлагнасан алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20.2.9 “*аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах*”, гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1: “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 282,436.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,482.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 105,184.5 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага, 175,770.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 282,436.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 25,369.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. ЗДТГ-ын мэргэжилтэн Б.Хосцэцэгийг малын үржил, бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалыг түр орлон гүйцэтгүүлэх хугацааг буруу тооцон 653.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ*”, 20.2.5 дахь “*... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалт болон ЗДТГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “*Түр орлон гүйцэтгүүлэх тухай*” тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Ажлын албаны мэргэжилтэн Б.Эрдэнэцэцэгт ИТХ-ын нарийн бичгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгүүлэхдээ албан тушаалын цалингийн зөрүүгээр бус үндсэн цалингийн 40 хувиар тооцон 829.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ*”, 20.2.5 дахь “*... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1-д “*Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 89,012.3 мянган төгрөгөөр тасалсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогын төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан ТТЗ-ийн 2,377.0 мянган төгрөгийн, ЗДТГ-ын 989.7 мянган төгрөгийн нийт 3,366.7 мянган төгрөгийн 3-аас дээш жилийн насжилттай авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь “Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг тооцоо нийлж баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

3. Өмнөх санхүүгийн тайланд тусгагдаагүй нийт 2,005.2 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан байна. Үүнд:

- ЗДТГ нь 2019-2024 оны хооронд үүссэн 798,0 мянган төгрөгийн татварын өрийг төлж шууд зардлаар тайлагнасан,
- Рашаант тосгоны Захирагчийн ажлын алба нь 2019-2024 оны хооронд үүссэн 307.2 мянган төгрөгийн өр, 2023-2024 онд үүссэн 900.0 мянган төгрөгийн санхүүгийн программын өрийг төлж шууд зардлаар тайлагнасан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухай оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.”, 14.4.3: бүх өр төлбөр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн тохиолдолд санхүүгийн тайланд тусгасны үндсэн дээр барагдуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүй урд оны тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй зардлыг тайлант жилд шууд зардлаар тайлагнасан зөрчлийг арилгалгүй, давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухай оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.3: бүх өр төлбөр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Хоролсүрэнд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5. ЗДТГ нь нийт 8,269.9 мянган төгрөгийг зориулалт бусаар буюу зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” -ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийж байх албан шаардлага хүргүүлэв.

6. Сумын ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн 330.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 16 нэр төрлийн 175,770.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...”* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Үнэлгээ ба хуваарилалт”* батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сумын ТТЗ	1	28,000.0			1	28,000.0	1	28,000.0				
Дүн	1	28,000.0			1	28,000.0	1	28,000.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгуул-лагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ	3	91,389.3			2	91,389.3	1	-					
Сумын ИТХ	2	829.0	1	829.0	1	-							
Сумын ЗДТГ	8	186,811.1	1	653.1	5	10,388.0	1	175,770.0	1	1	-		
Захирагчийн алба	3	1,207.2			2	1,207.2	1	-					
Дүн	15	280,236.6	2	1,482.1	9	102,984.5	3	175,770.0	1	1	-		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй шилэн дансны мэдээллийг ИТХ нь 10, ЗДТГ нь 12 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн Мөн ТТЗ нь 20, Рашаант тосгоны Захирагчийн алба 17 мэдээлэл хугацаа хоцроосон.	1	-			1	-				
Дүн	1	-			1	-				
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах төсвөөс тэмцээн, уралдааны зардлыг санхүүжүүлсэн.	1	2,200.0			1	2,200.0				
Дүн	1	2,200.0	-	-	1	2,200.0				
Нийт дүн	2	2,200.0			2	2,200.0	1			